



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ГСА-2022/25/СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Чойр хот
2022 он

Дарга тэргүүлэх аудитор:
Утас: 7054-3156 Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер:
Утас: 7054-3179 Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn

Ахлах аудитор:
Утас: 7054-3179 Цахим хаяг: Darkhanbatb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	14
3. Аудитын тайлан.....	15
3.1 Ерөнхий зүйл.....	15
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Материаллаг байдал	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	16
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	17
3.6.1 Төсвийн төлөвлөлт.....	17
3.6.2 Төсвийн гүйцэтгэл	17
3.6.3 Нэмэлт төсөв	18
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	18
3.8 Аудитын гол асуудал	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	19
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал илрээгүй.	19
4. Аудитын илрүүлэлт	19
4.1 Залруулсан алдаа	19
4.2 Төлбөрийн акт	20
4.3 Албан шаардлага	20
4.4 Зөвлөмж.....	22
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	24

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ГСА	Говьсүмбэр аймаг
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: govisumber@audit.gov.mn

Г ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
“ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ”-ИЙН
ТӨСВИЙН ЗАХИРАГЧ
Ш.ОТГОНЖАРГАЛ ТАНАА

2022.02.25 № *23*

танай _____-ны № _____-г

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Говьсүмбэр аймаг дахь “Политехник коллеж”-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Говьсүмбэр аймаг дахь “Политехник коллеж”-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Говьсүмбэр аймаг дахь “Политехник коллеж” нь суралцагчдаас хандив нэрээр хууль тогтоомжоор зөвшөөрөгдөөгүй 9,200.0 мянган төгрөгийг хураан авч байгууллагын үйл ажиллагаанд зарцуулсан, байгууллагын эзэмшлийн орон сууцыг түрээсийн гэрээгээр эзэмшүүлсэн ч гэрээг дүгнэж төлбөрийг баталгаажуулаагүй, батлагдсан орлогын төлөвлөгөөг биелүүлэх боломжтой байсан боловч дутуу бүрдүүлсэн, 18,000.0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл худалдан авч байгууллагын данс бүртгэлд бүртгэлгүй хөрөнгөд зарцуулсан, өмнөх аудитаар өгсөн авлага, өр төлбөргүй ажиллах албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4, Боловсролын тухай хуулийн 40.2, 40.7, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх заалт, УСНББОУС-17, санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг”, “иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

4208020062

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	351,386,619.5	311,945,811.1
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	11,256.0	0.0
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	11,256.0	0.0
31210	Төгрөг	11,256.0	0.0
31213	Арилжааны банк дахь харилцах	11,256.0	0.0
33	АВЛАГА	21,190,170.0	9,090,170.0
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,640,170.0	1,640,170.0
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	18,380,000.0	6,280,000.0
33500	Бусад авлага	1,170,000.0	1,170,000.0
33520	Хувь хүмүүсээс авах авлага	1,170,000.0	1,170,000.0
34	УРЬДЧИЛГАА	20,055,552.0	8,001,865.0
34710	Урьдчилгаа тооцоо	20,055,552.0	8,001,865.0
34713	Цалингийн урьдчилгаа	20,055,552.0	8,001,865.0
35	БАРАА МАТЕРИАЛ	310,129,641.5	294,853,776.1
35100	Түүхий эд материал	162,000.0	0.0
35130	Эм боох материал	162,000.0	0.0
35400	Хангамжийн материал	309,967,641.5	294,853,776.1
35410	Бичиг хэргийн материал	987,420.0	896,000.0
35420	Аж ахуйн материал	292,250,134.0	288,616,705.6
35430	Сэлбэг хэрэгсэл	253,000.0	0.0
35450	Барилгын засварын материал	1,315,000.0	0.0
35460	Хүнсний материал	15,162,087.5	5,341,070.5
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,574,204,074.8	4,223,109,459.2
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,574,204,074.8	4,223,109,459.2
39200	Биет хөрөнгө	4,365,576,824.9	4,015,067,209.2
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,898,012,275.2	3,898,012,275.2
39202	Хуримтлагдсан элэгдэл	-237,548,951.5	-356,323,427.3
39203	Авто-тээврийн хэрэгсэл	71,502,075.0	71,502,075.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	-71,502,075.0	-71,502,075.0
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	2,418,822,560.0	2,466,705,495.2
39206	Хуримтлагдсан элэгдэл	-1,901,498,519.8	-2,144,018,723.4
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	393,018,789.0	393,018,789.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	-263,202,927.2	-301,638,137.8
39214	Бусад үндсэн хөрөнгө	20,000,000.0	20,000,000.0
39215	Хуримтлагдсан элэгдэл	-6,166,666.8	-8,166,666.8
39217	Ном	44,140,266.0	47,477,605.0
39300	Биет бус хөрөнгө	208,627,249.8	208,042,250.0
39301	Програм хангамж	9,090,995.0	9,090,995.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	-8,399,745.2	-8,984,745.0
39303	Бусад биет бус хөрөнгө	209,886,000.0	209,886,000.0
39304	Хуримтлагдсан элэгдэл	-1,950,000.0	-1,950,000.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,925,590,694.3	4,535,055,270.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,025,134.1	9,729,053.1
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,025,134.1	9,729,053.1
41300	Өглөг	3,025,134.1	9,729,053.1
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	3,025,134.1	9,237,653.1
41360	Бусад өглөг	0.0	491,400.0
41361	Байгууллагад төлөх өглөг	0.0	491,400.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,922,565,560.2	4,525,326,217.2
51	Засгийн газрын хувь оролцоо	4,922,565,560.2	4,525,326,217.2

Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,681,905,393.6	3,681,905,393.6
51200	Хуримтлагдсан үр дүн	488,660,402.9	91,421,059.9
51210	Өмнөх үеийн үр дүн	899,903,106.8	476,560,402.9
51220	Тайлант үеийн үр дүн	-411,242,703.9	-385,139,343.1
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	751,999,763.7	751,999,763.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,925,590,694.3	4,535,055,270.3

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,979,262,239.0	1,999,610,383.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	23,061,706.0	58,426,583.8
120	Нийтлэг татварын бус орлого	23,061,706.0	58,426,583.8
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,807,200.0	7,025,000.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,529,000.0	5,846,000.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,278,200.0	1,179,000.0
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	474,436.0	47,340,274.2
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	13,780,070.0	4,061,309.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,956,200,533.0	1,941,183,800.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,947,726,500.0	1,893,147,500.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,947,726,500.0	1,893,147,500.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,474,033.0	48,036,300.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,474,033.0	48,036,300.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,390,504,942.9	2,384,749,726.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,390,504,942.9	2,384,749,726.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,239,792,955.8	2,330,625,429.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,089,158,797.0	1,176,739,190.9
210101	Үндсэн цалин	678,565,098.0	830,840,661.9
210102	Нэмэгдэл	410,593,699.0	345,898,529.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	135,544,529.0	153,875,995.1
210201	Тэтгэврийн даатгал	92,986,429.0	108,607,495.1
210202	Тэтгэмжийн даатгал	10,639,500.0	10,639,500.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,864,400.0	9,234,400.0
210204	Ажилгүйдлийн даатгал	2,775,100.0	2,308,600.0
210205	Эрүүл мэндийн даатгал	21,279,100.0	23,086,000.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	392,661,507.0	377,270,300.0
210301	Гэрэл, цахилгаан	28,636,744.3	23,198,390.0
210302	Түлш, халаалт	350,336,272.7	337,188,410.0
210303	Цэвэр, бохир ус	13,688,490.0	16,883,500.0
2104	Хангамж, бараа материалын зардал	103,852,088.0	102,073,202.1
210401	Бичиг хэрэг	11,252,550.0	14,202,576.0
210402	Тээвэр, шатахуун	6,918,462.7	5,229,730.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,472,131.3	5,047,458.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	13,285,000.0	6,566,200.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,291,410.0	9,971,791.0
210408	Бараа материал акталсны зардал	55,632,534.0	61,055,447.1
2105	Нормативт зардал	56,241,728.3	47,115,427.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,108,066.8	4,633,020.0
210502	Хоол, хүнс	51,743,661.5	42,482,407.0

Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,390,000.0	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,194,988.0	47,432,744.2
210602	Тавилга	0.0	8,080,000.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	436,300.0	0.0
210604	Урсгал засвар	27,758,688.0	39,352,744.2
2107	Томилолт, зочны зардал	2,079,100.0	288,000.0
210702	Дотоод албан томилолт	2,079,100.0	288,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,052,980.0	11,225,680.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,538,300.0	6,902,500.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,016,000.0	2,016,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	1,779,780.0	1,779,780.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	146,000.0	71,500.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	54,400.0	54,400.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	478,500.0	401,500.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	40,000.0	0.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	424,007,238.5	414,604,889.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,097,095.3	12,290,000.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	406,910,143.2	402,314,889.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	150,711,987.1	54,124,297.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,617,700.0	53,439,046.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	32,058,900.0	43,812,546.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,558,800.0	9,626,500.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	112,094,287.1	685,251.8
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	111,380,971.4	608,081.8
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	713,315.7	77,170.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-411,242,703.9	-385,139,343.1
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-411,242,703.9	-385,139,343.1

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,681,905,393.6	751,999,763.7	899,903,106.8	5,333,808,264.1
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,681,905,393.6	751,999,763.7	899,903,106.8	5,333,808,264.1
3	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	-411,242,703.9	-411,242,703.9
4	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,681,905,393.6	751,999,763.7	488,660,402.9	4,922,565,560.2
5	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,681,905,393.6	751,999,763.7	488,660,402.9	4,922,565,560.2
6	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	-12,100,000.0	-12,100,000.0
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,681,905,393.6	751,999,763.7	476,560,402.9	4,910,465,560.2
8	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	-385,139,343.1	-385,139,343.1
9	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	3,681,905,393.6	751,999,763.7	91,421,059.9	4,525,326,217.2

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,966,263,497.0	1,948,208,800.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,062,964.0	7,025,000.0
120	Нийтлэг татварын бус орлого	10,062,964.0	7,025,000.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,062,964.0	7,025,000.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,529,000.0	3,500,000.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,533,964.0	3,525,000.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,956,200,533.0	1,941,183,800.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,947,726,500.0	1,893,147,500.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,947,726,500.0	1,893,147,500.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,474,033.0	48,036,300.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,474,033.0	48,036,300.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,954,581,997.0	1,944,340,056.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,954,581,997.0	1,944,340,056.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,803,870,009.9	1,890,215,758.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,078,292,888.0	1,154,994,360.0
210101	Үндсэн цалин	667,591,519.0	691,783,747.0
210102	Нэмэгдэл	303,563,459.0	337,338,663.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	49,070,066.0	55,722,050.0
210104	Урамшуулал	58,067,844.0	70,149,899.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	151,496,266.0	155,917,220.0
210201	Тэтгэврийн даатгал	108,938,166.0	109,745,220.0
210202	Тэтгэмжийн даатгал	10,639,500.0	11,543,000.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,864,400.0	9,234,400.0
210204	Ажилгүйдлийн даатгал	2,775,100.0	4,260,400.0
210205	Эрүүл мэндийн даатгал	21,279,100.0	21,134,200.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	402,689,137.3	377,270,300.0
210301	Гэрэл, цахилгаан	28,636,744.3	23,198,390.0
210302	Түлш, халаалт	351,315,047.0	337,188,410.0
210303	Цэвэр, бохир ус	22,737,346.0	16,883,500.0
2104	Хангамж, бараа материалын зардал	45,541,409.3	27,293,388.0
210401	Бичиг хэрэг	4,647,300.0	4,465,800.0
210402	Тээвэр, шатахуун	4,860,348.0	4,518,330.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,472,131.3	5,047,458.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	13,285,000.0	8,466,200.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,276,630.0	4,795,600.0
2105	Нормативт зардал	55,865,131.3	41,694,610.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,353,527.0	4,971,020.0

Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210502	Хоол, хүнс	46,756,124.3	32,661,390.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,755,480.0	4,062,200.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,495,298.0	81,470,144.2
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,200,000.0	14,467,500.0
210602	Тавилга	0.0	11,249,400.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,745,000.0	940,900.0
210604	Урсгал засвар	13,550,298.0	54,812,344.2
2107	Томилолт, зочны зардал	2,079,100.0	288,000.0
210702	Дотоод албан томилолт	2,079,100.0	288,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,052,980.0	11,465,680.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,538,300.0	6,902,500.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,016,000.0	2,016,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	1,779,780.0	1,779,780.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	146,000.0	71,500.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	54,400.0	54,400.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	478,500.0	401,500.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	40,000.0	240,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,357,800.0	39,822,056.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	40,357,800.0	39,822,056.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	150,711,987.1	54,124,297.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,617,700.0	53,439,046.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,458,800.0	0.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	32,058,900.0	43,812,546.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,100,000.0	9,626,500.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	112,094,287.1	685,251.8
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	111,380,971.4	608,081.8
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	713,315.7	77,170.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	11,681,500.0	3,868,744.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	11,681,500.0	3,880,000.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,681,500.0	3,880,000.0
2200	Дотоод эх үүсвэрээр	11,681,500.0	3,880,000.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,681,500.0	3,880,000.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-11,681,500.0	-3,880,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.0	-11,256.0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	11,256.0	11,256.0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	11,256.0	0.0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,901,647,500.0	1,899,575,674.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,901,647,500.0	1,899,575,674.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,855,720,000.0	1,853,763,128.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,154,302,200.0	1,154,302,200.0
210101	Үндсэн цалин	713,157,000.0	691,091,587.0
210102	Нэмэгдэл	318,227,300.0	337,338,663.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	52,768,000.0	55,722,050.0
210104	Урамшуулал	70,149,900.0	70,149,899.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	155,830,700.0	155,830,700.0
210201	Тэтгэврийн даатгал	109,658,700.0	109,658,700.0
210202	Тэтгэмжийн даатгал	11,543,000.0	11,543,000.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,234,400.0	9,234,400.0
210204	Ажилгүйдлийн даатгал	2,308,600.0	4,260,400.0
210205	Эрүүл мэндийн даатгал	23,086,000.0	21,134,200.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	377,270,300.0	377,270,300.0
210301	Гэрэл, цахилгаан	25,915,600.0	23,198,390.0
210302	Түлш, халаалт	334,471,200.0	337,188,410.0
210303	Цэвэр, бохир ус	16,883,500.0	16,883,500.0
2104	Хангамж, бараа материалын зардал	25,981,000.0	25,512,258.0
210401	Бичиг хэрэг	4,465,800.0	4,465,800.0
210402	Тээвэр, шатахуун	2,737,200.0	2,737,200.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,298,700.0	5,047,458.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,683,700.0	8,466,200.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,795,600.0	4,795,600.0
2105	Нормативт зардал	36,971,700.0	36,970,590.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	247,000.0	247,000.0
210502	Хоол, хүнс	32,661,500.0	32,661,390.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,063,200.0	4,062,200.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	59,207,100.0	59,203,844.2
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,000,000.0	7,997,500.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	940,900.0	940,900.0
210604	Урсгал засвар	50,266,200.0	50,265,444.2
2107	Томилолт, зочны зардал	515,300.0	288,000.0
210702	Дотоод албан томилолт	515,300.0	288,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,521,100.0	4,563,180.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,016,000.0	2,016,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	1,782,000.0	1,779,780.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	495,000.0	71,500.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	54,400.0	54,400.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.0	401,500.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	673,700.0	240,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,120,600.0	39,822,056.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	40,120,600.0	39,822,056.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,927,500.0	45,812,546.0

Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2132	Бусад урсгал шилжүүлэг	45,927,500.0	45,812,546.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	43,813,000.0	43,812,546.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,114,500.0	2,000,000.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,901,647,500.0	1,899,564,418.2
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,893,147,500.0	1,892,539,418.2
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,893,147,500.0	1,892,539,418.2
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	8,500,000.0	7,025,000.0
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,500,000.0	3,500,000.0
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.0	3,525,000.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	11,256.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	167	167
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	83	83
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	52	52
620003	Үйлчлэх ажилтан	30	30
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	83	83
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	45	45
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	38	38

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	48,036,300
21	УРСГАЛ ЗАРДАЛ	48,036,300
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	40,332,630
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	692,160
210101	Үндсэн цалин	692,160
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	86,520
210201	Тэтгэврийн даатгал	86,520
2104	Хангамж, бараа материалын зардал	1,781,130
210402	Тээвэр, шатахуун	1,781,130
2105	Нормативт зардал	4,724,020
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,724,020
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,146,300
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,350,000
210602	Тавилга	11,249,400
210604	Урсгал засвар	4,546,900
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,902,500
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,902,500
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,626,500
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,626,500
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,626,500
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	77,170
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	77,170
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	48,036,300
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	48,036,300
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	48,036,300
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгө, орлогын бүрдүүлэлт, төсөв зарцуулалттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Дарханбат гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр, Дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/14 дүгээр албан бичгээр хуульд заасан хугацаанд ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Говьсүмбэр аймаг дахь Политехник коллеж нь “Байгальд ээлтэй технологи хөгжүүлэгч сургууль” болно гэсэн зорилт дэвшүүлсэн бөгөөд аймгийн Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 92.5 хувьтай үнэлэгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говьсүмбэр аймаг дахь Политехник коллеж нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 2,390,504.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 35,857.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 25,100.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говьсүмбэр аймаг дахь политехник коллежийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 390,535.4 мянган төгрөгөөр буюу 7.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмч дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	11.26	0.00	-11.26
Авлага	21,190.17	9,090.17	-12,100.00
Урьдчилгаа	20,055.55	8,001.87	-12,053.69
Бараа материал	310,129.64	294,853.78	-15,275.87
Үндсэн хөрөнгө	4,574,204.07	4,223,109.46	-351,094.62
Нийт хөрөнгө	4,925,590.69	4,535,055.27	-390,535.42
Өр төлбөр	3,025.1	9,729.1	6,703.92
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	4,922,565.6	4,525,326.2	-397,239.34
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,925,590.69	4,535,055.27	-390,535.42

Авлага дансны үлдэгдэл 12,100.0 мянган төгрөгөөр буурч 9,090.1 мянган төгрөг болсон нь 2017 оны 2-5 сард бүрэн төлөгдсөн авлагыг шууд орлогоор бүртгэж бүртгэлийн алдаагаар үүссэн авлага байсныг нотолсон тул тус сургуулийн захирлын 2021 оны А/69 дүгээр тушаалаар данснаас хассан байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 8,001.8 мянган төгрөг болж 12,053.7 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх жилийн санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон төлбөрийн актыг барагдуулсантай холбоотой байна. Тайлант онд шинээр урьдчилгааны авлага үүсээгүй.

Бараа материалын дансны үлдэгдэл 294,853.7 мянган төгрөг болж 15,275.8 мянган төгрөгөөр буурсан ба байгууллагын захирлын тушаал, өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэрийн дагуу 61,055.4 мянган төгрөгийн бараа материалыг акталсан нь голлох нөлөө үзүүлжээ.

Үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 4,574,204.0 мянган төгрөг байсан ба 351,094.6 мянган төгрөгөөр буурч 4,223,109.5 мянган төгрөгийн үлдэгдэл тайлагнажээ. Тайлант хугацаанд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 44,002.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 3,337.3 мянган төгрөгийн сурах бичиг шилжүүлснийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэж, 3,880.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг дансанд бүртгэсэн бөгөөд 402,314.9 мянган төгрөгийг элэгдэл байгуулсан нь нөлөөлсөн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 9,729.1 мянган төгрөг болж 6,703.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь хувь хүний орлогын албан татварт 6,763.3 мянга, нийгмийн даатгалд 2,474.3 мянган төгрөгийн өр төлбөр тайлагнасан нь нөлөөлжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,525,326.2 мянган төгрөг болж 397,239.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 385,139.3 мянга, нягтлан бодох бүртгэлийн алдааны залруулга 12,100.0 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалжээ.

Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 20,348.1 мянган төгрөгөөр буюу 1.03 хувиар нэмэгдсэн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө 46,865.8 мянга, нэмэлт санхүүжилтийн орлого 39,562.3 мянган төгрөгөөр нэмэгдэж, төсвийн санхүүжилт 54,579.0 мянган төгрөгөөр буурсан нь нөлөөлжээ.

Нийт зардалд өмнөх оноос материаллаг хэмжээний өөрчлөлт ороогүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвийн санхүүжилтээр 2,299,689.3 мянга, үйл ажиллагааны орлого 8,500.0 нийт 2,308,189.3 мянган төгрөгөөр нийт зарлагыг 2,308,189.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 385,541.9 мянган төгрөгөөр бууруулж, 1,922,647.4 мянган төгрөгөөр баталсан бөгөөд тайлант хугацаанд нийт 3 удаа төсөвт өөрчлөлт оруулж, жилийн эцсийн байдлаар 1,901,647.4 мянган төгрөгөөр санхүүжилтийг баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71804 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,901,647.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,893,147.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 8,500.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,892,539.4 мянган төгрөгийн санхүүжилт, 7,025.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,899,564.4 мянган төгрөгийг зарцуулж, 608.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Орлогыг дутуу төвлөрүүлснээс зардлыг санхүүжүүлэх дүн 1,475.0 мянган төгрөгөөр буурчээ.

Хүснэгт 2. Гүйцэтгэлийн тайлангийн үзүүлэлт (мянган төгрөгөөр)

Хөтөлбөрийн код нэр	Арга хэмжээний код, нэр	Төлөв	Гүйц	Зөрүү
71804-Мэргэжлийн боловсрол	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	1,823,058.50	1,821,090.48	1,968.02
	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	45,927.50	45,812.55	114.95
	81806-Дотуур байрны үйлчилгээ	32,661.50	32,661.39	0.11

Нийт дүн	1,901,647.50	1,899,564.42	2,083.08
-----------------	---------------------	---------------------	-----------------

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Байгаль орчин аялал жуулчлалын газраас модны урамшуулал 4,695.0 мянга, аймгийн Засаг даргын Тамгын газраас эмнэлгийн орны материал болон тээврийн зардал 7,987.5 мянга, жолооны сургалт 3,070.0 мянга, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт 8,875.0 мянга, гагнуурчин, токарчны сургалт 584.0 мянга, актлагдсан хөрөнгө борлуулсан орлого 3,336.0 мянга, байрны түрээс 5,968.8 мянга, гал тогооны түрээс 1,555.0 мянга, заалны түрээс 350.0 мянга, дотуур байрны оюутнуудаас хураан авсан орлого 9,200.0 мянга, түргэвчилсэн шинжилгээний орлого 2,415.0 мянга, залруулгын 2,350.0 мянга, нийт 50,386.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, байгууллагын үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аудитаар Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108, А/111 дүгээр тушаалаар батлагдсан ерөнхий чиглэлд тусгагдсан асуудлыг онцолсон.

3.8 Аудитын гол асуудал

Суралцагчдаас хууль тогтоомжоор зөвшөөрөгдөөгүй төлбөр, хураамжид 9,200.0 мянган төгрөгийг хураан авч байгууллагын үйл ажиллагаанд зарцуулсан, байгууллагын эзэмшлийн орон сууцыг түрээсийн гэрээгээр эзэмшүүлсэн ч гэрээг дүгнэж төлбөрийн үлдэгдлийг баталгаажуулаагүй, батлагдсан орлогын төлөвлөгөөг биелүүлэх боломжтой байсан боловч дутуу бүрдүүлсэн, байгууллагын баланст бүртгэлгүй хөрөнгөнд 18,000.0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл авч зарцуулсан, өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй зэрэг зөрчлүүд нь аудитын дүгнэлтийг өөрчлөхөд нөлөөлсөн.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.8-д заасан мэдээллийн давхардал, ач холбогдол үр нөлөөг харгалзан Шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Говьсүмбэр аймаг дахь Политехник коллеж нь 2021 онд нийт 3,007,481.4 мянган төгрөгийн 84 мэдээллийг байршуулахаас 2,521,354.8 мянган төгрөгийн 19 мэдээллийг байршуулаагүй, 21 мэдээллийг хугацаа хоцроосон байна. .

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн худалдан авах ажиллагааны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Тухайлбал: Захирлын тушаалаар үнэлгээний хороо байгуулсан боловч үйл ажиллагаа явуулаагүй. Хоол хүнсний материал нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалтгүйгээр шууд гэрээ байгуулсан.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Говьсүмбэр аймаг дахь Политехник коллеж нь өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 5 сарын 25-ны 01/103 дугаартай албан бичгээр ирүүлсэн бөгөөд аудитын явцад өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжилтийг тооцоход цахим төлбөрийн системд хяналт тавих зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагын багшийн илүү болон багц цагийн нэмэгдэл олголтын бодит үр дүн гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй байна гэж үзсэн тул дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй гэж үзсэн.

Мөн цалин хөлсний бүртгэлийг хууль тогтоомжийн дагуу хийж гүйцэтгээгүй өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд давтагдан гарч байгаа нь дотоод хяналт хангалтгүй байгааг харуулж байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт **675,257.5** мянган төгрөгийн **17** алдаа зөрчил илэрснээс, **4,268.0** мянган төгрөгийн **3** алдааг залруулж, **555.0** мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, **668,534.5** мянган төгрөгийн 10 зөрчилд 8 албан шаардлага хүргүүлж, **1,900.0** мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Харилцах дансанд тушаасан цалингийн урьдчилгааг үйл ажиллагааны орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалт, санхүүгийн тайлангийн зохистой байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй тул завсрын аудитаар зөрчил арилгах зөвлөмж өгч залруулсан.
2. Мөнгөн гүйлгээний тайланд орлогын дүнг илүү илэрхийлснээс цэвэр мөнгөн гүйлгээ 2,242.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4, 20.2.4, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан журмын 3 дугаар хавсралтын 6 дугаар зүйлийн 6.7 дахь заалт, санхүүгийн

тайлангийн үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй тул аудитын явцад залруулсан.

3. Төсвийн гүйцэтгэлийн тайланд орлогыг 918.0 мянга, буцаан төвлөрүүлсэн санхүүжилт 608.1 мянга нийт 1,526.1 мянган төгрөгөөр илүү тайлагнаж төсвийн гүйцэтгэлийн тохируулгыг хийгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4, 20.2.4, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан журмын 3 дугаар хавсралтын 8 дугаар зүйлийн 8.3 дах заалт, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй тул аудитын явцад залруулсан.

4.2 Төлбөрийн акт

1. Байгууллагын дотоод журмыг үндэслэн 5,550.0 мянган төгрөгийн тэтгэмж олгосон боловч 555.0 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутган тооцоогүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22.1.1, Татварын ерөнхий газрын даргын 2019 оны А/261 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Хувь хүний орлогыг албан татвараас чөлөөлөх, албан татварын хөнгөлөлт эдлүүлэх журам"-ын 2.2 дах заалт, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-т заасны дагуу төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

1. Завсрын аудитаар өр төлбөргүй ажиллах зөвлөмж өгсөн боловч хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайланд ХХОАТ, НДШ, байгууллагад төлөх өр төлбөртэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дах заалт, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т заасны дагуу албан шаардлага өгөв.

2. Завсрын аудитаар авлага барагдуулах зөвлөмж өгсөн боловч хэрэгжүүлж ажиллаагүй, авлагын үлдэгдэлтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дах заалт, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т заасны дагуу албан шаардлага өгөв.

3. Цахим төлбөрийн системд хяналт тавьж ажиллаагүйгээс 24 иргэн, ААНБ-ын 10,976.3 мянган төгрөгийн худалдан авалт шивэгдээгүй, 10 байгууллага 720.1 мянган төгрөгийн төлбөрийн баримт илүү бичигдсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, Сангийн сайдын 2017 оны 347-р тушаалаар батлагдсан журмын 6 дугаар зүйлийн 6.5 дахь заалтыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10, 4.2.1.11-т заасны дагуу албан шаардлага өгөв.

4. Нийгмийн даатгалын тайланд 2,221.0 мянган төгрөгийн цалин хөлсийг илүү тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4,

Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дүгээр зүйлийн 17.1, 17.1.1 дах заалтыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1, 4.2.1.11-т заасны дагуу албан шаардлага өгөв.

5. Байгууллагын хөрөнгөнд бүртгэлгүй, өмчлөлийн асуудал шийдэгдээгүй хувь хүний тракторт 18,000.0 мянган төгрөгийн сэлбэг худалдан авч тавьсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4.2, 20 дугаар зүйлийн 20.2.4 дах заалт, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т заасны дагуу албан шаардлага өгөв.

6. Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал зөрчин цалингийн зардлаас 1,206.1 мянган төгрөгийн шагнал урамшууллын зардал олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн сайдын 2014 оны 5 дугаар тушаалын 6 дугаар хавсралт, Сангийн сайдын 2021 оны 190-р тушаал, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т заасны дагуу албан шаардлага өгөв.

7. Хоол хүнсний материал нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулсан боловч үйл ажиллагаа явуулаагүй, сонгон шалгаруулалтгүйгээр шууд гэрээ байгуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 46 дугаар зүйлийн 46.1.3 дах заалт, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т заасны дагуу албан шаардлага өгөв.

8. Шилэн дансны цахим хуудсанд 21 мэдээллийг хугацаа хоцроосон, тухайн жилийн төсөвт орсон 2 өөрчлөлт, 5 сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий 10 худалдан авалтын 554,470.3 мянга, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгийн 30,311.1 мянган төгрөгийн 4, хөрөнгө зарцуулах 21,953.4 мянган төгрөгийн 15 тушаал тус тус мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.4, 6.4.5, 6.4.8 дах заалт, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т заасны дагуу албан шаардлага өгөв.

9. Батлагдсан орлогын төлөвлөгөөг 1,475.0 мянган төгрөгөөр тасалсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дах заалт, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т заасны дагуу албан шаардлага өгөв.

10. Суралцагчдаас хууль тогтоомжоор зөвшөөрөгдөөгүй 9,200.0 мянган төгрөгийг хандив нэрийн дор хураан авч байгууллагын үйл ажиллагаанд зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.4, Боловсролын тухай хуулийн 40 дүгээр 40.2, 40.7 дах заалт, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т заасны дагуу албан шаардлага өгөв тогтоов.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Санхүүгийн тайланд өр төлбөрөөр тусгагдаагүй 1,900.0 мянган төгрөгийн тэтгэмжийг 2020 оны байгууллагын даргын тушаалыг үндэслэн 2021 оны төсвөөс олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.3, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6 дах заалт болон санхүүгийн тайлангийн тасалбар болголт гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайланд өр төлбөрөөр тусгагдаагүй аливаа төлбөрийг санхүүжүүлэхгүй байх, зөвхөн батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Ашиглалтын хугацаа дууссан 58 нэр төрлийн 448 ширхэг 266,660.3 мянган төгрөгийн хөрөнгөөс цаашид ашиглах боломжтой хөрөнгийг үнэлж бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20.2.4, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан журмын 7.1 дах заалт, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Ашиглах боломжтой хөрөнгийг үнэ тогтоох, ашиглах боломжгүй тохиолдолд акталж устгах

3. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Байгууллагын эзэмшлийн орон сууцыг түрээсийн гэрээгээр эзэмшүүлсэн боловч гэрээг дүгнэж төлбөрийн үлдэгдлийг баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4.5, 20 дугаар зүйлийн 20.2.4, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж:

Түрээслүүлсэн байрнаас гарахад төлбөр тооцоог дуусгах, түрээсийн гэрээг дүгнэх, хэрэгжилтэд хяналт тавих

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 11 дүгээр сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/Д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Говьсүмбэр аймаг дахь Политехник коллеж	17	675,257.5	3	4,268.1	1	555.0	10	668,534.4	3	1,900.0